



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 03 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдааныг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар “Зөвшөөрлийн тухай” хуультай нийцүүлэн Шуудангийн зохицуулалтын зарим нөхцөл шаардлага, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай багц асуудал (Үүнд: “Шуудангийн харилцан холболтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай-2019 оны 54 тоот тогтоол; “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага” /Шуудангийн сүлжээ байгуулах/ батлах тухай; “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг батлах тухай); ХХЗХ-ны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад тохируулга хийх тухай; Бусад: “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны 3 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэлийг баталсан болно.

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр энэхүү хуулийн шинэчилсэн найруулгад салбарын зохицуулалтын журам, баримт бичгүүдийг нийцүүлэх, давхардал, хийдлийг арилгах, шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар “Зөвшөөрлийн тухай” хуультай нийцүүлэн Шуудангийн зохицуулалтын зарим нөхцөл, шаардлага, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, батлах тухай 3 багц асуудлыг боловсруулан холбогдох үндэслэл танилцуулга, хорооны тогтоолын төсөл, тогтоолын хавсралт баримт бичиг, эрх ашиг нь хөндөгдөж байгаа эрх бүхий хуулийн этгээдийн ирүүлсэн санал, саналын товчоо, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, нөлөөллийн шинжилгээ зэргийг авч хэлэлцэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага” батлах тухай /Шуудангийн сүлжээ байгуулах/ тогтоолыг хавсралтын хамт батлав. Энэхүү нөхцөл, шаардлагыг баталснаар Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу ХХЗХ-ноос харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулах боломжийг бүрдүүлнэ. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус Хорооны 2019 оны 52 тоот тогтоолыг хүчингүй болгов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр

зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 23 тоот “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай тогтоолыг батлахаар шийдвэрлэв. Уг тогтоолыг баталснаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулах боломжийг бүрдүүлэх оршино. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2019 оны 53 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцов.

Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шуудангийн харилцан холболтын журам”-ын 1.1, 1.2, 1.3.1, 1.3.2, 1.3.3, 3.1.3, 4.2 дахь заалтад өөрчлөлтүүд оруулахаар шийдвэрлэж, 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 24 тоот “Шуудангийн харилцан холболтын журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлав.

Тус хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн шинээр баталсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан ХХЗХ-ны 2023 оны 22, 23, 24 тоот 3 тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

Хуралдаанаар тус хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.10 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 13.1 дэх хэсэг, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Байгууллагын 2022 оны тусгай зөвшөөрлийн орлогын тайлан, дансны авлагын дүнг шийдвэрлэх саналын тухай” танилцуулга, хуралдааны тэмдэглэл болон тэмдэглэлийн хавсралт жагсаалтын төслийг тус тус хуралдаанаар авч хэлэлцээд, тус хуралдаанаас “Дансны авлагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар Хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэв. Тэмдэглэлд, энэхүү хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх талаар дараах арга хэмжээг авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /3.Эрдэнэчулуун/-т үүрэг болгохоор тогтов. Үүнд: Хорооны хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан “Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад тохируулга хийх жагсаалт”-д багтсан 30 тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээний нийт 207,003,370.07 /Хоёр зуун долоон сая гурван мянга гурван зуун далан төгрөг долоон мөнгө/ төгрөгийн шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгох, тодорхойгүй орлогоос хаах, илүү төлөлтөөс шилжүүлэн тооцох, зөвшөөрлийн ангилал шилжсэн, хуулийн этгээд нь татан буугдсан, гэрээний тусгай нөхцөлтэй зөвшөөрлүүдийн 2022 онд тооцсон авлагын дүнгээс хасаж тохируулга хийх арга хэмжээг авах; Энэхүү хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан жагсаалтын дагуу авлагыг тохируулан тайлагнах арга хэмжээ авч ажиллахыг ЗУХАГ, Санхүүгийн хэлтэст тус тус даалгав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдааны бусад асуудлаар, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 28 тоот тогтоолын хавсралтаар баталж, 2021 оны 19 дүгээр тогтоол, 2022 оны 62 тоот тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан “ХХЗХ-ны хуралдааны дэг”-ийн талаар танилцуулга, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах танилцуулав. Тус хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс хэлэлцсэн асуудлаар

гаргасан саналыг үндэслэн хорооны хуралдааны дэг баримт бичиг нь хууль эрх зүй, дүрэм журмын нийцэл, давхардал, уялдаа холбоог хянаж үзэх, процедурын шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах (Хорооны гишүүн А.Лувсан-Очир), “ХХЗХ-ны хуралдааны дэг”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгов.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-03-09